



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №29



2018 оны 8-р сарын 20-24

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны 8 дугаар сарын 24-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт **1170** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 104(8.9%) галзуугийн эрсдэлд өртсөн, 1040(88.9%) хачигт халдвар, 12(1.0%) бэтэг, 1(0.1%) хумхаа, 7(0.6%) боом, 6(0.5%) тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол эзэлж байна.

1.1. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:



Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Дорнод, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Төв аймгийн 106 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын **1040** сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 16.6%-иар бага байна. Эпидемиологийн 33-р долоо хоногтой харьцуулахад 13 сэжигтэй тохиолдлоор их байна.



8 дугаар сарын 24-ны өдрийн байдлаар хачигт риккетсиозын 769 сэжигтэй тохиолдлын 185(24%), хачигт энцефалитын 180 сэжигтэй тохиолдлын 32(17.7%), хачигт боррелиозын 91 сэжигтэй тохиолдлын 24(26.4%) тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр тус тус онош батлагдаж, 129 тохиолдлын онош үгүйсгэгдээд байна.

1.2. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Архангай, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Завхан, Сэлэнгэ аймгийн 29 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт **104** тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 12%-иар бага байна. Эпидемиологийн 33-р долоо хоногтой харьцуулахад 2 эрсдэлд өртсөн тохиолдлоор их байна.



1.3 Бэтгийн хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол:

Ховд аймгийн Ховд суманд бэтгийн хүний өвчлөлийн сэжигтэй 1 тохиолдол бүртгэгдэж, өвчтнийг онош тодруулахаар 8-р сарын 22-нд сорьц дээжилж, 23-нд ЗӨСҮТ-ийн лабораторит шинжилгээ хийхээр хүлээн авав.

1.4 Мэрэгч амьтны сэжигтэй дуудлага:

Нийслэлийн 6 дүүрэгт (БЗД, БГД, ХУД, СБД, СХД, ЧД)-ийн хэмжээнд нийт 47 удаагийн амьтны дуудлаганд үйлчилж, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.

8 дугаар сарын 24-ны өдрийн байдлаар нийслэлийн БГД, БЗД, СХД-ийн хэмжээнд 3 удаагийн ирүүлсэн амьтны дуудлагад үйлчилсэн. Сорьц материалд лабораторийн шинжилгээ хийгдэж байна.

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Монгол улсад:

Шувуу үхсэн тухай мэдээ:

8 дугаар сарын 15-нд Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын “Сангийн Далай” нууранд (сумын төвөөсөө зүүн урд зүгт 45 км-т) ангир, цахлай, нугас, бор галуу, болжмор төрлийн 1341 шувууд тодорхойгүй үхсэн тул 8-р сарын 16-17-ны хооронд шувууны сэг зэмийг цуглуулж устгасан. Тус газар Аймгийн ОБГ, БОАЖГ, МХГ, ХХААГ-ын МЭХ, ЗӨСТ хамтран ажилласан. 8-р сарын 17-нд сорьц дээжилж 21-ны УМЭАЦТЛ-ийн шинжилгээний дүнгээр шувууны томуу болон Ньюкастлийн өвчний үүсгэгчийн ген тус тус илрээгүй байна.

Эх сурвалж: Говь-Алтай ЗӨСТ

Шувуу үхсэн тухай мэдээ:

8 дугаар сарын 20-нд ХУД-ын 12-р хорооны Биокомбинатын 120-р Цэргийн ангийн урд талбайд 30 орчим болжмор тодорхойгүй үхсэн тул устгаж, халдваргүйтгэл хийсэн. Тус газар ХУД-ын Онцгой байдал, Мал эмнэлэг, Мэргэжлийн хяналтын газар хамтран ажилласан.

Эх сурвалж: ХУД-ийн МЭГ

Олон улсад:

Эбола вирүст халдвар:

8 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар Хойд Киву мужийн (Mabalako, Beni, Butembo, Oicha, Musienene), Итури мужийн (Mandima) эрүүл мэндийн төвөөс нийт 78 сэжигтэй (51 батлагдсан, 27 болзошгүй) тохиолдол, үүнээс 44 нас баралт мэдээлэгдээд байна.

Эх сурвалж: ДЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:

БНХАУ-ын Зянсу мужид Африкийн гахайн мялзан өвчин гахайн аж ахуйд бүртгэгдэж, 615 гахай өртсөнөөс, 88 гахай өвчилж, 527 гахайг устгасан байна.

Эх сурвалж: ДАЭМБ

Баруун нилийн халуурал өвчин:

Грек улсын Флорина хотын Дутики Македониа мужид Баруун нилийн халуурал өвчин бүртгэгдэж, 2 адуу өртсөнөөс, 1 адуу өвчилсөн байна.

Эх сурвалж: ДАЭМБ


Мал, амьтны боом өвчин:

Кыргызстан улсын Кара-Кулжинску мужид *Bacillus anthracis* зүйлийн нянгаар үүсгэгдсэн мал, амьтны боом өвчин бүртгэгдэж, 40 үхэр өртсөнөөс, 1 үхэр өвчилж үхсэн байна.

Эх сурвалж: ДАЭМБ

Шүлхий өвчин:


Гвиней улсын Ванко хотын Дабола мужид шүлхий өвчин бүртгэгдэж, 453 үхэр өртсөнөөс, 43 үхэр өвчилсөн. Тус мужид хорио цээрийн дэглэм тогтоосон байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:

Украин улсын Полтав мужид Африкийн гахайн мялзан өвчин гахайн аж ахуйд бүртгэгдэж, 336 гахай өртсөнөөс, 15 гахай өвчилж үхэн, 321 гахайг устгаж хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллажээ.



Эх сурвалж: ДАЭМБ

Жич: Энэ долоо хоногт Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Завхан, Сэлэнгэ, Хөвсгөл, Өмнөговь, Хэнтий аймгийн ЗӨСТ-үүд үйл явдалд суурилсан тандалтын мэдээгээ илрүүлсэн. Салбар төвүүд ШУН-ийн eop@nczd.gov.mn мэдээгээ ирүүлж байна уу?